



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын нэрийг
ШИНЭ нам болгож өөрчилсөн намын дүрмийн
өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх
өргөдөл (хүсэлт)-ийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, Н.Батзориг, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Ц.Цогт, Д.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын дарга Ц.Гантулгаас гаргасан “намын нэрийг ШИНЭ нам болгож өөрчилсөн намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх” тухай өргөдөл (хүсэлт)-ийг шүүгч М.Батсуурийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намаас, намын оноосон нэрийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг анх 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр шүүхэд ирүүлснийг хүлээн авч, нягтлан шалгах ажиллагааг явуулсны үндсэн дээр Улсын дээд шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 04/3389 дүгээр албан бичгээр “шаардлагатай баримтыг бүрэн ирүүлээгүй” гэсэн үндэслэлээр буцаасан.

Үүний дараа “зөрчлийг залруулсан” гэх үндэслэлээр тус намын нэрийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дахин гаргаж, 68 хуудас (флаш-1) баримт хавсаргаж ирүүлснийг шүүх хүлээн авсан.

Тус өргөдөлд “... 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр намын 3 дугаар Их хурлаараа Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, намын дүрмийн 1 дүгээр бүлгийн 1.3, 23 дугаар зүйлийн 23.1.7 дахь хэсэгт заасан заалтууд болон тус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн намын оноосон нэрээ ШИНЭ болгож өөрчилсөн тул бүртгүүлэх”, мөн хүсэлтдээ “... хууль журмын дагуу намын нэр өөрчлөгдсөнийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэх” гэжээ.

Шүүхээс тухайн өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагыг

хангасан эсэх, мөн Улсын дээд шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 04/3389 дүгээр албан бичгийн үндэслэлд дурдсан алдаа зөрчил арилсан эсэхийг шалгаж, 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсны үндсэн дээр Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын даргаас гаргасан “намын нэрийг ШИНЭ нам болгож өөрчилсөн намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх” тухай өргөдөл (хүсэлт)-ийг хангаж шийдвэрлэлээ.

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын даргаар Ц.Гантулга сонгогдсон тухай өөрчлөлтийг тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэсэн байх тул тус намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд мөн болно.

Тус намын өргөдөлд дурдсан асуудал нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “үүсгэн байгуулах баримт бичиг” гэж эрх бүхий этгээдээс гаргасан хуулийн этгээд байгуулах шийдвэр, хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг; 4.1.6-д “хуулийн этгээдийн мэдээлэл” гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:” гээд 10.1.6-д “үүсгэн байгуулах баримт бичиг”, 10.1.8-д “хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр” гэж тус тус заасны дагуу улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөж журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх ...”-ээр заасан тул Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын өргөдөлд дурдсан асуудлыг 2005 оны Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэхээр байна.

Улс төрийн намын тухай (2005 оны) хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна”, 11 дүгээр зүйлийн 11.2-т “Намын дүрэмд дараахь нийтлэг зүйлийг тусгана:” гээд 11.2.2-т “намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбаа”, 11.2.6-д “намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах журам”, 13 дугаар зүйлийн 13.2-т

“Дараахь асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.” гээд 13.2.3-т “... намын нэрийг өөрчлөх” гэж;

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын дүрмийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Намын удирдах дээд байгууллага нь намын Их хурал байна”, 22.2-т “Их хурлын хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит Их хурлыг 4 жилд нэгээс доошгүй удаа Төв зөвлөл зарлан хуралдуулна. Их хурлын хуралдааны дэгийг тухайн Их хурал өөрөө тогтооно”, 22.4-т “Их хурлын сонгогдсон төлөөлөгчдийн олонх нь хүрэлцэн ирснээр тухайн хурал хүчин төгөлдөр болно. Их хуралд оролцож буй төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй болно”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Дараахь асуудлыг намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гээд 23.1.7-д “намын нэрийг өөрчлөх” гэж тус тус зохицуулжээ.

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын Төв зөвлөлийн хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор намын 3 дугаар Их хурлаа 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зарлан хуралдуулсан; тус хурлаар 2 асуудал хэлэлцэхээр баталсны дотор намын нэр солих асуудал багтаж, хуралд 456 төлөөлөгч оролцсоноос 452 төлөөлөгчийн санал¹-аар намынхаа нэрийг ШИНЭ нам гэж өөрчилж, уг оноосон нэрийн өөрчлөлттэй холбогдуулан намын дүрмийн 1 дүгээр бүлэг, 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болох “Намыг “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Нам” гэж нэрлэнэ. Намын товчилсон нэр “ШИНЭН” байна. Намын нэрийг англи хэлээр “Citizens Coalition for Justice Party” гэж орчуулна” гэснийг “Намыг ШИНЭ нам гэж нэрлэнэ. Намын товчилсон нэр “ШН” байна. Намын нэрийг англи хэлээр “New Party” гэж орчуулна” гэсэн өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн нь өргөдөлд хавсарган ирүүлсэн баримт²-аар тогтоогдож байна.

Түүнчлэн, өмнөх Улсын дээд шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 04/3389 дүгээр албан бичгийн үндэслэлд заасан “... бичлэгийн 01 минут 34 секундэд “тус намын дарга Ц.Гантулгаас намын нэршлийг солих санал асуулгыг дэмжиж байгаа нь мандатаа өргөг гэсэн нэр томъёогоор явах нь зүйтэй” гэсэн ч төлөөлөгчдийн хэдэн хувь нь дэмжсэн, дэмжээгүй талаар саналаа өгсөн, санал хураалт хэрхэн явагдаж байгаа нь тодорхойгүй, шууд Тооллогын комиссын 01 дүгээр тогтоол гарсан талаар танилцуулж, намын нэр солих үйл ажиллагаанд 456 төлөөлөгч оролцон санал өгсөн, хурлын заалнаас 452 гишүүн дэмжиж, татгалзсан 2, түдгэлзсэн 2 ... гэсэн атлаа уг тогтоолоо шүүхэд ирүүлээгүй, түүнчлэн намын оноосон нэрийн өөрчлөлттэй холбогдуулан дүрэмдээ өөрчлөлт оруулах талаар санал хураалт явагдсан эсэх нь ч тухайн бичлэгээс тодорхой харагдахгүй байна.

¹ Дэмжсэн- 452, татгалзсан - 2, түдгэлзсэн-2

² Тус намын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Төв зөвлөлийн хурлын тэмдэглэл, хурлын зар, намын даргын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 09 дүгээр тушаал, түүний хавсралт, 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит 3 дугаар Их Хурлын “... Их хурлын ирц баталгаажуулах тухай” 01 дүгээр, “... Их хурлын Тэргүүлэгчид, даргыг батлах тухай” 02 дугаар, “... Их хурлын хэлэлцэх асуудлыг батлах тухай” 06 дугаар, “... Намын нэр солих тухай” 07 дугаар, “Намын дүрэмд өөрчлөлт оруулах тухай” 09 дүгээр тогтоол, мөн өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын “... намын ээлжит 3 дугаар Их хурлын санал хураалтын дүнгийн тухай” 01 дүгээр тогтоол, Их хурлын төлөөлөгчдийн бүртгэл, фото зураг, хуралдааны үйл явцыг баримтжуулсан болон телевизийн (хураангуй) дүрс бичлэг (флаш) зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, тухайн хурлын үйл ажиллагааг бүрэн буулгаж, эрх бүхий этгээд нь гарын үсэг зурсан хуралдааны тэмдэглэл байхгүй учир энэ талаар дүгнэх боломжгүй, дан ганц хурлын тойм (02 минут 53 секунд) бичлэг нь тус намын 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 3 дугаар Их хурлын үйл явцыг бүрэн илэрхийлсэн баримт гэж үзэхэд хангалтгүй ...” гэсэн зөрчилтэй холбогдуулан тус намын 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит 3 дугаар Их Хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын “... намын ээлжит 3 дугаар Их хурлын санал хураалтын дүнгийн тухай” 01 дүгээр тогтоол, хуралдааны үйл явцыг баримтжуулсан 25 минут 15 секундийн дүрс бичлэг зэргийг ирүүлсэн байх тул тухайн зөрчил арилсан гэж үзнэ.

Ийнхүү нам нь хууль, дүрэмд заасан өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд, хуралд оролцсон нийт төлөөлөгчийн олонхын саналаар намынхаа нэрийг өөрчилсөн; Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 4/9488 дугаар албан бичгээр “Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам /ШИНЭН/ нь нэрээ өөрчилж Шинэ нам /ШН/ болоход уг нэртэй адил, төсөөтэй нэр бүхий хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлгүй” гэх хариуг шүүхэд ирүүлсэн; 2023 оны 10 дугаар сарын 16, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг олгосон нь Улс төрийн намын тухай (2005 оны) хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Нам үйл ажиллагаандаа дараахь нийтлэг зарчмыг баримтална.” гээд 5.1.4-т “дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ”, 6.2-т “Намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж, болон бусад намын нэртэй адил байхыг, түүнчлэн намыг хүний нэрээр нэрлэхийг хориглоно” гэснийг зөрчөөгүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “улсын бүртгэлийн гэрчилгээ” гэж тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолж, улсын бүртгэлийн байгууллагаас эрх бүхий этгээдэд цаасан болон цахим хэлбэрээр олгох баримт бичгийг” хэлнэ, 8 дугаар зүйлийн 8.8.3-т “хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн хүрээнд гэрчилгээг дахин авах хүсэлт гаргасан” бол улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгохоор заасан учир намын оноосон нэрийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг хангаж шийдвэрлэж байгаа энэ тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгох нь зүйтэй гэж үзэж, тус намын “... хууль журмын дагуу намын нэр өөрчлөгдсөнийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэх” хүсэлтийг мөн хангаж шийдвэрлэлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай (2005 оны) хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасныг тус тус баримтлан Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам /ШИНЭН/-ын нэрийг ШИНЭ нам /ШН/ гэж өөрчлөн бүртгэж, намын дүрэмд өөрчлөлт оруулсугай.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухайн хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 8.8.3-т заасныг баримтлан ШИНЭ нам /ШН/-д улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгосугай.

3.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ